

БАТЛАВ  
ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ ДЭД БҮТЭЦ ТӨСЛИЙН  
ЗОХИЦУУДАГЧ /Ж.ГАНБААТАР/

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМ, ГАШУУНСУХАЙТ БООМТЫН  
ХАЙРХАН БАГИЙН АВТО ЗАМ, ГАДНА ГЭРЭЛТҮҮЛЭГ, ГАДНА ТОХИЖИЛТ,  
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АЖИЛД ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ХЯНАЛТ  
ТАВИХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

Зорилго	Өмнөговь аймгийн Ханбогд сум, Гашуунсухайт боомтын Хайрхан багийн авто зам, гадна гэрэлтүүлэг, тохижилт, ногоон байгууламжийн ажилд техник, технологийн хяналтыг олон улсын жишгээр хэрэгжүүлэх, хяналтыг сайжруулах, ажлын чанарыг дээшлүүлэх, тайлан бэлтгэх
Үндэслэл	1.Авто замын тухай хуулийн 21.1 дэх хэсэг, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны №228 тушаалын хавсралт “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам” 2.Барилгын тухай хуулийн 42.1.6, 42.3, МУ-ын ЗГ-ын 2021 оны №343-р тогтоол, түүний хавсралт “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журам” 3.МУ-ын Сангийн сайдын 2024 оны 2 дугаар сарын 29-ны №38 тушаалын “Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монгол талын хөрөнгө оруулалт /улсын хэмжээнд/” төслийн хүрээнд санхүүжигдэх төсөл, арга хэмжээний жагсаалт”;
Хугацаа	1. Захиалагч болон Зөвлөхийн хооронд байгуулах гэрээнд хугацааг тодорхой тусгах, гэрээнд заасан төлбөрт багтаан Зөвлөх үйлчилгээг үзүүлнэ. 2. Төслийн гэрээний дагуу БУА эхлэх өдрөөс зөвлөх үйлчилгээний ажил эхэлж, барилгын ажлын баталгаат хугацаа дуусахад дуусгавар болно. 3. Зөвлөхийн хяналтын баг нь авто зам, гадна гэрэлтүүлэг, гадна тохижилт, ногоон байгууламжийг барилгын ажлын саруудад, барилгын ажил дууссаны дараа улсын комисс ашиглалтад хүлээн авах хүртэл, мөн баталгаат хугацааны үед тус тус ажиллана. 4. Хайрхан багийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа болон баригдах барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээний БУА-тай авто зам, гадна гэрэлтүүлэг, тохижилт, ногоон байгууламжийн ажлыг уялдуулан аль болох гэрээний хугацааг сунгахгүй, илүү зардал гаргахгүй байхад анхаарч ажиллана.
Ажлын хамрах хүрээ	Техник технологийн хяналт тавих ажлын жагсаалт: а/ Хайрхан багийн 0.987 км авто зам б/ Авто зам, талбайн гэрэлтүүлэг в/ Гадна тохижилт, ногоон байгууламж Хяналтын баг нь дээрх ажлуудыг батлагдсан ажлын зураг, техникийн шаардлагын дагуу зөвшөөрөгдсөн материал, тоног төхөөрөмж ашиглан ажил гүйцэтгэх технологийн дагуу барилгын ажлыг явуулж байгаа эсэхэд өдөр тутам, байнгын техник технологийн хяналтыг тавихдаа дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд: 1. Нарийвчилсан зураг төслийг хянаж, илүү сайжруулалт, эдийн засгийн хэмнэлттэй, дэвшилтэт технологи, шалгарсан аргыг санал болгохыг эрмэлзэх, ингэхдээ зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, захиалагчтай зөвшөөрөлцсөн байх; 2. Гүйцэтгэгчийн БУА-тай уялдуулан Хяналтын ажлын төлөвлөгөө /график/-г боловсруулан Захиалагчаар баталгаажуулан мөрдөн ажиллана. 3. Хэрэв зураг төсөлд алдаа гарвал илүү зардал гаргахгүйгээр шийдлийг гаргаж, зураг төсөл зохиогч, захиалагч, гүйцэтгэгчтэй зөвлөлдөж асуудлыг нааштайгаар шийдвэрлэн ажиллана. 4. Хайрхан багийн авто зам, гадна гэрэлтүүлэг, тохижилт, ногоон байгууламжийн ажлыг бусад барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, зам, талбай, тохижилтын ажилтай уялдуулж зохион байгуулан хяналт /өндөржилт, ажлын дэс дараалал гэх мэт/ тавина. 5. Хяналтын зөвлөх компани нь “Барилгын ажлын талбайн зохион



- байгуулалтын зураг”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах төлөвлөгөөг шалгаж баталгаажуулан захиалагчид ирүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
6. Гүйцэтгэгчийн ажиллах хүчний нөөцөд хяналт тавих, холбогдох шаардлага, зөвлөмжийг өгч хэрэгжүүлэх;
  7. Гүйцэтгэгчийн байрлах түр байр, машин механизм, тоног төхөөрөмж, материалын талбайн байршлын талаар захиалагчтай зөвлөлдөх, хамтран ажиллах;
  8. Гүйцэтгэгчийн БУА-ын төлөвлөгөө, ажиллах хүч, тоног төхөөрөмжийн төлөвлөгөөг хянан баталж захиалагчид ирүүлэх, хэрэгжүүлэн ажиллах;
  9. Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийн байдлыг шалган, зохих тохиргоо зүгшрүүлэлт хийсэн, ажлын шаардлага хангасан эсэхийг батлах;
  10. Хяналтын зөвлөх компани нь БУА-д байнгын техникийн хяналтыг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг график, гэрээний дагуу зохиогчтой хамтран хянаж баталгаажуулахаас гадна захиалагч болон эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх болон ажлын явцад хийнэ. Шалгалтын үед илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулах;
  11. Гүйцэтгэгчийн байгуулах хяналтын лабораторийн шаардлага хангаж буй эсэхийг шалгаж, ашиглах зөвшөөрөл олгон, лабораторийн туршилт, шинжилгээний ажилд өдөр тутмын хяналт тавьж, шинжилгээний үр дүнг баталгаажуулах;
  12. Гүйцэтгэгчийн чанарын хяналтын төлөвлөгөө болон байгаль орчныг нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөг батлах;
  13. Замын далан, суурийн үе, цементээр бэхжүүлсэн суурь, асфальтбетон хучилт, бетон эдлэл, зуурмагт ашиглагдах материал, элс хайрган хольц, цемент, буталсан чулуу, ус, арматур, төмөр бетон хоолой, бусад авто замын тоноглолд болон гэрэлтүүлгийн шон, гэрэлтүүлэгч, самбар, кабель, уян ган хоолой, холболтын хэрэгслүүдэд ашиглагдах, мөн мод бут, сүүдрэвч, сандал, бетон гүүрэнд ашиглах бүх материалуудын эх үүсвэрийг баталгаажуулж, зөвшөөрөл өгөх;
  14. Замын болон гадна гэрэлтүүлгийн трассыг улсын геодезийн өндөржилтийн цэгтэй холбох, завсрын өндөржилтийн цэгүүдийг байгуулах, замын тэнхлэгийн шугамыг тавих зэрэгт хяналт тавин тэдгээрийг баталгаажуулах;
  15. Гүйцэтгэгчийн гаргасан газрын түвшин, замын хөндлөн огтлолын зураг, бүх ажлын геодезийн хэмжилтийн үр дүнг шалган баталгаажуулж, ажил гүйцэтгэх зөвшөөрөл өгөх;
  16. Гүйцэтгэгчийн гаргасан хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, түр зам барих төлөвлөгөөг хянаж, батлах, хяналт тавих;
  17. Зөвлөх нь ажлын явцад гүйцэтгэгчийн хийсэн ажлын тоо хэмжээг геодезийн болон бусад хэмжилтийн багаж ашиглан хянаж, тухай бүр тайлан гарган Захиалагчид ирүүлэх;
  18. Замын далан, суурийн үе, цементээр бэхжүүлсэн суурь, асфальтбетон хучилтын ажлын технологийн дараалал, өндрийн түвшин, үеийн нягтруулалт, гадаргуугийн хөндлөн хэвгий, тэгш байдлыг өдөр бүр шалгаж, дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэх зөвшөөрлийг бичгээр өгч байх;
  19. Авто зам дор байрлуулах төмөр бетон хоолой, гадаргуугийн ус зайлуулах байгууламж болон замын тэмдэг, тэмдэглэгээ, бусад тоноглол, гэрэлтүүлгийн шон, бетон суурийг суулгахаас өмнө урьдчилан ажлыг хянан батлах;
  20. Гүйцэтгэгчийн үйлдвэрлэж байгаа асфальт болон бетон хольцын орц ба чанарт өдөр тутмын хяналт тавих;
  21. Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж, ажил, ажиллах хүчний даатгалын гэрээг хянах;
  22. Гүйцэтгэгчийн ажлын зураг, материал хийц хэсэг, тоног төхөөрөмж, ажлын аргачлал, өөрчлөгдөх бүрд Зөвлөх тэдгээрийг хянаж Захиалагч



	<p>байгууллагатай зөвшилцөж зөвшөөрөл олгох;</p> <p>23. Ажлын бус өдөр, амралтын цагаар болон илүү цагаар гүйцэтгэгч ажиллах хүсэлт гаргавал ажиллах үүрэгтэй;</p> <p>24. Ажлын явцад ажлын зураг, техникийн шаардлага зөрчих, батлагдаагүй материал, тоног төхөөрөмж ашиглах, батлагдсан аргачлалаас өөр аргаар ажил гүйцэтгэх бүрд Зөвлөх нь Гүйцэтгэгчийн ажлыг зогсоох эрх, үүрэгтэй. Ажил зогсоох шаардлагыг албан бичгээр өгнө.</p> <p>25. Зөвлөх нь долоо хоног, сарын эхээр Гүйцэтгэгчийг урин талбайн уулзалт хийх бөгөөд энэ уулзалтаар долоо хоногт болон сард төлөвлөсөн ажлын явц, гүйцэтгэл, ажлын чанар, ажлын графикийн өөрчлөлт зэрэг барилгын ажлын явцтай холбоотой асуудлыг хэлэлцэх ба уулзалт бүрийн тэмдэглэлийг хөтөлж байна. Онцгой нөхцөл байдал үүссэн тухай бүрд уулзалт зохион байгуулж байна.</p> <p>26. Зөвлөх нь аливаа асуудлыг Захиалагчаар дамжуулан холбогдох байгууллагуудтай албан бичгээр харилцан шийдвэрлэж байна.</p> <p>27. Гүйцэтгэгчийн хийсэн ажил чанарын шаардлага хангаагүй бол түүнийг дахин хийлгэх, засварлуулах зэрэг арга хэмжээг тухай бүрд авах бөгөөд ийм ажилд төлбөр хийгдэхгүй.</p> <p>28. Зөвлөх нь БУА-д ямар нэг өөрчлөлт гарахаар бол захиалагчид танилцуулах эрх үүрэгтэй боловч гэрээний үнийн дүнгийн тодорхой хувиас доош өртөг бүхий ажлын өөрчлөлтийг ФИДИК-ийн гэрээний дагуу бие даан шийдэх эрхтэй. Нарийвчилсан хувь болон зөвлөхийн бусад эрх, үүргийг Захиалагч-Зөвлөхийн хооронд хийгдэх гэрээгээр зохицуулна.</p> <p>29. Гүйцэтгэгч гэрээний заалтуудыг зөрчиж, гэрээт хугацаандаа ажлаа дуусгаагүй бол Зөвлөх нь гэрээний зохих заалтын дагуу гэрээний торгууль ноогдуулах санал гаргаж захиалагчид танилцуулах үүрэгтэй бөгөөд торгууль ноогдуулах асуудлыг захиалагч шийдвэрлэн Зөвлөхөд танилцуулна.</p> <p>30. Гүйцэтгэгч гэрээт хугацаандаа ажлаа дуусгаж чадахгүй, ажлыг чанартай хийж гүйцэтгэх чадваргүй зэрэг асуудал тодорхой болсон нөхцөлд Зөвлөх нь гүйцэтгэгчийн гэрээг цуцлан өөр гүйцэтгэгч сонгох, туслан гүйцэтгэгч авах зэрэг саналаа захиалагчид танилцуулна. Гэрээ цуцлах, өөр гүйцэтгэгч сонгох, туслан гүйцэтгэгч нэмж авах асуудлыг Захиалагч шийдвэрлэнэ.</p> <p>31. Гүйцэтгэгч байгууллага ажлаа дуусган улсын комисст ажлаа хүлээлгэн өгсний дараа Зөвлөх нь ажил дууссан тухай гэрчилгээ бичиж, Захиалагчид хүргүүлнэ.</p> <p>32. Гүйцэтгэгчийн гэрээнд заасан баталгаат хугацаа дууссаны дараа Зөвлөх нь зам ашиглалтын байдлыг хянан үзэж, ажлын чанар муугаас болж гарсан эвдрэлийг Гүйцэтгэгчээр засуулан эцсийн гэрчилгээ бичиж барьцааны болон буцаах мөнгийг Гүйцэтгэгч байгууллагад эргүүлэн төлөх хүсэлтийг Захиалагчид гаргах;</p> <p>33. Баталгаат засварын хугацаа дуусах үед авто замын байдал болон Гүйцэтгэгчийн хийх шаардлагатай засварын ажлын талаар Захиалагчид танилцуулах;</p> <p>34. Барилгын ажил дууссаны дараа авто замыг хүлээж авахад Захиалагчийн мэргэжлийн тусалцаа үзүүлэх;</p> <p>35. Захиалагчтай өдөр тутам харилцаж бүх талын мэдээллээр хангах;</p> <p>36. Захиалагчийн харилцан тохиролцсон бусад ажлууд;</p>
<p>Зөвлөхөд тавигдах шаардлага</p>	<p>Зөвлөхөд дараах шаардлагууд тавигдана. Үүнд:</p> <p>а) Зөвлөх нь уг үйлчилгээг үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд /туслан компанид мөн хамаарна/ байх ба авто зам, гадна гэрэлтүүлэг, тохижилт, ногоон байгууламжийн ажилд байнгын хяналт тавих багуудыг ажиллуулна.</p> <p>б) Хяналтын багийн ажилтнуудын амьдрах байр, тэдгээрийн тавилга, хэрэгсэл, компьютер болон албан аргаар хянагдах бусад тоног төхөөрөмж, талбайд болон төвтэйгөө шуурхай холбоо барих хэрэгсэл, геодезийн багаж, ажлын хээрийн хувцас гэх мэт ажил гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай хувцас, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн</p>



хангагдсан байх ба тээвэр, холбоо, цахилгаан, дулаан, бичиг хэрэг, хангамж болон бусад бүх зардлыг Зөвлөх өөрөө бүрэн хариуцна.

- c) Хяналтын багийн ахлагч буюу Ерөнхий инженерээс бусад голлох мэргэжилтнүүд урьдчилан гаргасан ажлын хуваарийн дагуу барилгын ажлын талбайд байнга ажиллах шаардлагатай.
- d) Хяналтын баг нь дор хаяж 8-н голлох мэргэжилтэнтэй байх ба багт ажиллах ажилтны тоо үүгээр хязгаарлагдахгүй. Голлох мэргэжилтнүүд нь дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

#### **А. Ерөнхий инженер-1**

Ерөнхий инженер нь уг Зөвлөх үйлчилгээг бүрэлд нь удирдан ажиллах бөгөөд Зөвлөхийн ажлын үр дүнг Захиалагчийн өмнө бүрэн хариуцна. Ажлын талбайд ажиллах зөвлөх үйлчилгээтэй холбоотойгоор оффист ажиллах ажилтнуудыг нэгдсэн удирдлагаар хангах бөгөөд ажлын талбайд байнга байх шаардлагагүй боловч сард 2-оос доошгүй удаа ажлын талбайд очиж ерөнхий хяналт тавих, тайлан бэлтгэж ажиллах үүрэгтэй.

- Авто замын барилгын инженер болон түүнээс дээш зэрэгтэй;
- Мэргэжлээрээ 12-оос дээш жил, үүнээс 10-аас дээш жил зураг төсөл болон авто замын барилгын ажлын хяналтын чиглэлээр ажилласан;
- Зөвлөх эсвэл мэргэшсэн инженерийн зэрэгтэй;
- Авто зам, гүүрийн барилга, засварын ажилд технологийн хяналт хийх "Тэргүүн инженер"-ийн итгэмжлэлтэй;
- Удирдах ажлын туршлагатай;

#### **Б. Авто замын инженер буюу хэсгийн ахлагч-1**

Хэсгийн ахлагч нь өөрийн хариуцан ажиллаж буй хэсэг дэх зөвлөх багийн ажлыг өдөр тутмын удирдлагаар ханган, ажлын талбайд байнга ажиллана.

- Авто замын барилгын инженерийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй;
- Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил, үүнээс 8-аас дээш жил зураг төсөл болон авто замын барилгын ажлын хяналтын чиглэлээр ажилласан;
- Зөвлөх эсвэл мэргэшсэн инженерийн зэрэгтэй;
- Авто зам, гүүрийн барилга, засварын ажилд технологийн хяналт хийх "Ахлах инженер"-ийн итгэмжлэлтэй;
- Удирдах ажлын туршлагатай;

#### **В. Хиймэл байгууламжийн эсвэл барилгын инженер-1**

- Авто замын болон барилгын инженерийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй;
- Мэргэжлээрээ 7-оос доошгүй жил, үүнээс 5-аас дээш жил авто замын барилгын ажлын хяналтын чиглэлээр ажилласан;
- Авто зам, гүүрийн барилга, засварын ажилд технологийн хяналт хийх "Инженер"-ийн итгэмжлэлтэй;

#### **Г. Материалын инженер-1**

- Авто замын барилгын эсвэл барилгын материалын инженерийн мэргэжлийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй;
- Мэргэжлээрээ 6-аас доошгүй жил, үүнээс 4-өөс дээш жил авто замын барилгын ажлын хяналтын чиглэлээр ажилласан;
- Авто зам, гүүрийн барилга, засварын ажилд материалын хяналт тавих "Инженер"-ийн итгэмжлэлтэй;

#### **Д. Хэмжилтийн инженер-1**

- Авто замын барилгын эсвэл геодезийн инженерийн мэргэжлийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй;
- Мэргэжлээрээ 6-аас доошгүй жил, үүнээс 4-өөс дээш жил авто замын барилгын ажлын геодези хэмжилтийн чиглэлээр ажилласан туршлагатай;
- Авто зам, гүүрийн барилга, засварын ажлын геодезийн хяналт тавих "Инженер"-ийн итгэмжлэлтэй;

#### **Е. Цахилгаан эсхүл автоматикийн инженер -1**

- Тухайн чиглэлээр их, дээд сургууль төгссөн, "мэргэшсэн" буюу түүнээс дээш зэрэгтэй байх;

	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс 3-аас дээш жил барилгын ажлын хяналтын чиглэлээр ажилласан;</li> <li>- Удирдах ажлын туршлагатай;</li> </ul> <p><b>Ё. Ногоон байгууламж хариуцсан инженер-1</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Тухайн чиглэлээр их, дээд сургууль төгссөн байх;</li> <li>- Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажилласан, үүнээс 3-аас дээш жил хяналтын чиглэлээр ажилласан;</li> <li>- Удирдах ажлын туршлагатай;</li> </ul> <p><b>Ж. ХАБЭА-н инженер-1</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- ХАБЭА-н тусгай эрх бүхий сургалтын үнэмлэхтэй авто зам, барилгын инженер эсхүл ХАБЭА-н инженерийн мэргэжлийн баклавар болон түүнээс дээш зэрэгтэй;</li> <li>- Авто зам эсхүл барилгын салбарт ХАБЭА-н чиглэлээр 3-аас дээш жил ажилласан байх;</li> </ul> <p><b>К. Төсөвчин -1</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Тухайн чиглэлээр их, дээд сургууль төгссөн байх.</li> <li>- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, үүнээс 3-аас дээш жил хяналтын чиглэлээр ажилласан;</li> <li>- Удирдах ажлын туршлагатай;</li> </ul> <p>Зөвлөх нь ажлыг шуурхай хянах, гүйцэтгэгчийн ажлыг саатуулахгүй байх үүднээс Зөвлөх нь 2500см<sup>3</sup>-ээс багагүй багтаамж бүхий 1-ээс доошгүй авто машинтай байна.</p> <p>Зөвлөх үйлчилгээнд ашиглагдах хээрийн иж бүрэн лаборатори, хэмжилтийн багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь түрээсийн байж болно.</p>
Тайлангийн хуваарь	<ol style="list-style-type: none"> <li>1. <b>Эхлэлийн тайлан:</b> Зөвлөх үйлчилгээний ажил эхэлснээс хойш 1 сарын дотор захиалагчид хүргүүлнэ.</li> <li>2. <b>Сар, улирал тутмын явцын тайлан:</b> Зөвлөх нь барилгын ажлын явцын тайланг /өдөр тутмын тайланг цахимаар/ сар бүр, улирал тутам гарган Захиалагчид ирүүлнэ. Тайланд барилгын ажлын явц, чанар байдал, хүн хүч, машин механизм, материалын хангамж, цаг агаар, барилгын ажлын явцад гарсан аливаа өөрчлөлт, шийдвэрүүд, цаашид авах арга хэмжээ, холбогдох фото зураг, график тооцоо, дүгнэлтийг тусгасан байна.</li> <li>3. <b>Гүйцэтгэлийн тайлан:</b> Зөвлөх нь авто замын барилгын ажил дууссаны дараа гүйцэтгэлийн тайлан бичиж Захиалагчид хүргүүлнэ.</li> <li>4. <b>Төслийн эцсийн тайлан:</b> Барилгын ажлын баталгаат хугацаа дуусгавар болсноор авто замын барилгын ажилд хяналт тавих Зөвлөх үйлчилгээ дуусгавар болсонд тооцон төслийн эцсийн тайлан бичиж Захиалагчид хүргүүлнэ.</li> </ol> <p>Хяналтын зөвлөх компани нь Захиалагч болон гүйцэтгэгчтэй Монгол хэл дээр харилцах бөгөөд бүх тайлан, материалаа Монгол хэл дээр бэлтгэн танилцуулна.</p>

ХЯНАСАН:

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН МЕНЕЖЕР ...  ... /Г. ДЭЛГЭР/

ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЛБАНЫ ДАРГА ...  ... /А. ЕРМЕК/

БОЛОВСРУУЛСАН:

ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЛБАНЫ ДОТООД ХЯНАЛТ, ХАБЭА-Н ИНЖЕНЕР ...  ... /Б. ЗӨВЦЭЦЭГ/